

МОНГОЛ УЛСЫН ГЕОПОЛИТИКИЙН ОРЧНЫ ХУВЬСАЛ: ДҮН ШИНЖИЛГЭЭ, ЭРСДЛИЙН МАГАДЛАЛ

Д.Уламбаяр*

Гадаад, дотоод орчны хурдацтай өөрчлөгдөж буй үйл явцтай уялдан шийдвэр гаргах бүх түвшинд мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээ, үнэлгээнд тулгуурлахын ач холбогдол хэлбэрэлтгүй өсөн нэмэгдсээр байна. Харилцан шүтэлцэл, даяаршлын үйл явц нийгмийн бүхий л хүрээг хамарч, гадаад, дотоод орчин маш хурдан өөрчлөгдөж, тиймээс ойрын ирээдүйн төлөв байдлыг ч урьдчилан төсөөлөх боломж тун бүрхэг байгаа нь өнөөгийн олон улсын харилцааны үндсэн шинж болов. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байх гэдэг нь даяаршлын үед харьцангуй ойлголт бөгөөд тэгэх тусмаа дангаараа бүрэн хангах боломжгүй юм. Тиймээс үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь тасралтгүй үргэлжлэх үйл явц бөгөөд үүн лүгээ үндэсний аюулгүй байдлын судалгаа, дүн шинжилгээ ч тасралтгүй хийгдэж байх учиртай ажгуу.

Бүс нутгийн болон олон улсын аюулгүй байдал, дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үр нөлөө, зах зээлийн конъюнктур, дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшиг, шинэ өвчний цар тахал, уламжлалт бус аюул зэрэг геополитикийн гадаад орчин, төсөв, мөнгө, хөрөнгө оруулалтын бодлого, ардчилал, засаглалын чанар зэрэг геополитикийн дотоод орчны мэдэгдэхүйц хувьсал улс орны удирдлагыг богино хугацаанд оновчтой, шинжлэх ухааны үндэслэлтэй зөв шийдвэр гаргах, урьдчилан сэргийлэх дипломат ажиллагаа (preventive diplomacy), хямралын менежментийг (crisis management) шуурхай хэрэгжүүлэхийг шаардах болов.

Геополитик бол газарзүй, орон зайн байршил, хүч чадавхид суурилсан гадаад улс төрийн бодлого даруй мөн бөгөөд түүнд нөлөөлж буй гол хүчин зүйл нь хүрээлэн буй улс орнуудын гадаад бодлого, олон улсын харилцааны орчин, харин дотоод хүчин зүйл нь эдийн засгийн ухаан бодлого, зөв тогтолцоо, засаглалын чанар, ардчилалын төлөвшил, хүний эрхийн баталгаажилт юм.

Хүйтэн дайн дууссанаар Монголын геополитикийн орчин үндсээрээ өөрчлөгдөж, далайд гарцгүй (*land-locked*), цөмийн зэвсгээр хүрээлэгдсэн (*nuclear-locked*), хоёр их гүрний дунд хашигдсан (*power-locked*), мөн монгол угсаатнаар хүрээлэгдсэн (*mongols ethno-locked*) сул бүрхүүлтэй цоо шинэ нөхцөл байдал буй болов.

*Д.Уламбаяр, ХИС-ийн багш, доктор (Ph.D)

Геополитикийн шинэ орчинд Монгол Улс үндэсний язгуур эрх ашгийг дээдэлсэн, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, бие даасан, нээлттэй гадаад бодлого явуулах болсон нь ХХ зууны сүүлчийн улиралд Монгол Улсын гадаад харилцаанд гарсан хамгийн том ололт мөн.

Хүйтэн дайн дууссаны дараах Монголын геополитикийн гадаад, дотоод орчныг 1990-ээд он, шинэ мянганы эхний арван жил, хоёр дахь арван жилийн эхэн гэж гурав хувааж болохоор байна. Эдгээр цаг хугацаа, үе шат өөр өөрийн өвөрмөц онцлог ялгаатай байсан хийгээд байгаа нь тодорхой байна.

Монгол Улс геополитик, орон зайн хувьд хоёр гол бүс нутгийн уулзвар дээр оршдог. Эхнийх нь Зүүн Хойд Азийн (ЗХА) бүс, удаах нь Төв Азийн бүс юм. ЗХА нь Зүүн Ази-Номхон далайн их бүс нутгийн бага бүс нутаг агаад ОХУ-ын Алс Дорнодын бүс, БНХАУ-ын Зүүн Хойд бүс, Монгол Улс, ЗХА-ийн «зүрхэн газарт» орших Солонгосын хойгийн хоёр улс БНСУ, БНАСАУ болон Япон улсыг багтаасан геополитик, улс төр-физик газарзүйн ухагдахуун бөгөөд харин өргөн утгаар нь авч үзвэл Алс Дорнодыг халин гарч АНУ-ын геополитик, аюулгүй байдлыг эрх ашиг, Канад улсын эдийн засгийн сонирхол хосолсон бүс нутаг болно. Дурдсан бүс нутгийн улс орнуудын хооронд түүхийн үүднээс ужигарч тунаж үлдсэн газар нутгийн маргаан, цөмийн хөтөлбөр, дахин нэгдлийн асуудал гээд тулгамдаж буй зангилаа асуудлууд буй.

ЗХА-ийн бүс нутгийн улс орнууд нийгэм-улс төрийн хувьд зөрчилтэй, олон янз боловч харилцан шүтэлцээтэй, бие биеэсээ улам их шалтгаалж, бие биедээ зайлшгүй шаардлагатай болж, олон талаараа бүхэл бүтэн дэлхий ертөнцийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн. Энэ бүс нутагт хоршин хөгжих, хамтаар хожих, хамтын аюулгүй байдлын байнгын тогтолцоог бүрдүүлэхийн зайлшгүй нь дэлхий хэмээх гариг улам бүр жижигрч, бие биетэйгээ улам бүр харилцан хамааралтай болж, ямар ч хүчирхэг эдийн засагтай улс, гүрэн ч өөрийнхөө хөгжил дэвшил, үндэсний аюулгүй байдлаа дангаараа хангаж, хөтлөн авч явах бололцоогүй болсон гэдэгт үндэслэж байна.

Сайхь сав нутагт дэлхийн II дайны дараа тогтсон Солонгосын хойгийн *status quo* хүйтэн дайн дууссанаас хойш шийдвэрлэгдэж чадаагүй тунаж үлдсэн цорын гагц цэг мөн бөгөөд эдүгээ ноцтой хурцадах төлөв ажиглагдаж эхлэв.

Хүйтэн дайн дууссаны дараах Монгол Улсын гадаад харилцаанд буй болсон шинэ хүчин зүйл нь хоёр хөршөөс гадна АНУ, Япон, Өрнөд Европ зэрэг дэлхийн бодлогод шийдвэрлэх нөлөөтэй зонхилох орнууд, хандивлагчдын бүлэг, Европын Холбоо болон олон улсын байгууллагууд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болсон явдал юм. Үүний уг сурвалж нь Монголд гарсан ардчилсан өөрчлөлт, зах зээлийн эдийн засагт шилжих

үйл явц байсан бөгөөд тэдгээр орнууд ч Монгол Улсыг ардчилсан шинэ тогтолцоонд шилжихэд бүх талын дэмжлэг үзүүлж, нөгөө талд урд, хойд хоёр хөршид нь шилжилтийг амжилттай даван туулж буйг загвар болгон харуулах давхар зорилго ч агуулж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиж, ардчилал, хүний эрх, эрх чөлөөг жинхэнэ ёсоор баталгаажуулах бодлого явуулж эхэлсэн нь Өрнөдийн орнууд Монгол Улстай харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх гол түлхүүр байв. Дараах хүчин зүйл нь Өрнөдийн орнуудын Монгол Улс дахь бодит сонирхлыг илэрхийлж буй Монгол Улсын геополитикийн байршил юм. Тухайлбал: ЕХ-ны Дэд Комиссар Ханс ван ден Брук (Hans van den Broek) анх удаа 1996 оны 9 дүгээр сард Монгол Улсад айлчлах үеэрээ хэлэхдээ: *«Монгол Улс геополитикийн чухал байрлалтай тул Европын Холбоо, Монгол Улстай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх сонирхолтой байдаг»* гэжээ. 2004 онд ЕХ-ноос Монгол Улсад Суурин төлөөлөгчөөр сууж байсан доктор Клаус Эберманн хэлэхдээ: Монгол Улсын газарзүйн байрлал нь Европын Холбоог Солонгосын хойгтой холбож байгаа юм гэсэн нь буй.

Төв Азийн геополитикийн орчинд шинээр тусгаар тогтносон олон улсын харилцааны шинэ субъектүүд буй болж, энэ бүс нутагт эрчим хүчний үлэмж нөөц байгаа нь тогтоогдов. НАТО-гийн дорно зүг тийш тэлэх үйл явц, АНУ-ын ашиг сонирхол дурдсан бүс нутагт нэмэгдэж Төв Азийн геополитикийн орчин аажмаар хувьсан өөрчлөгдсөөр байна.

Геополитикийн гадаад орчны өөрчлөлтийн дүн шинжилгээ, эерэг хандлага ба сорилт: шинэ мянганы эхэнд:

Монгол Улс хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах гадаад бодлогын тэргүүлэх зарчмыг удирдлага болгон 2003 онд ОХУ-тай “Сайн хөршийн уламжлалт түншлэл”, 2009 онд “Стратегийн түншлэл”, 2003 онд БНХАУ-тай “Сайн хөршийн харилцан итгэсэн түншлэл”, 2011 онд “Стратегийн түншлэл”-ийн харилцааны эрхзүйн үндсийг тавьсан нь хоёр талын харилцааг чанарын шинэ шатанд гаргасан үйл явдал бөгөөд мөн «гуравдагч хөрш»-ийн бодлогыг хэрэгжүүлэх таатай нөхцөл болов.

2011 оны 2 дугаар сард шинэчлэн батлагдсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ийн 14.1-т: *«ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлэнэ»* гэж заасан нь 1994 оны заалтыг дахин нотолсон хэрэг юм. Харин *«Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзана»¹* гэсэн өмнөх баримтлалын

1. Монгол Улсын гадаад бодлогын хөх ном: 2007-2011, ГХЯ, УБ., 2011, 114 дэх тал

заалтыг хэвээр үлдээсэн нь тэнцвэртэй харилцах бодлоготой зөрчилдөж болохуйц санаа гэж ойлгогдож байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Монгол Улс 2002 онд ОХУ-тай 3543 км урт хилийг хамтран шалгаж эцэслэн тодотгосон бол, 2001-04 онд БНХАУ-тай хилээ хоёрдахь удаагаа хамтран шалгаж, 4676.8 км урт хилийн шугамыг тогтоож, Монгол Улсын хилийн багануудыг анх удаа боржин чулуугаар шинэчлэн босгов. Ийнхүү өнөөдөр Монгол Улсын хилийг эмжсэн 8219 км 895 м урт хил олон улсын гэрээ, хэлэлцээрээр баталгаажсан нь тус улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгаа болж байна.

2003 оны эцэст “*их өр*”-ийг тэглэсэн нь Монгол-ОХУ-ын цаашдын харилцаанд нэн таатай нөхцөл бололцоог бүрдүүлээд зогсохгүй олон улсын тавцан дахь Монгол Улсын нэр хүндэд үлэмж сайнаар нөлөөлсөн хүчин зүйл болов. Их өрийн асуудлыг үлэмж хөнгөлөлттэй нөхцөлөөр нэг мөр шийдсэн нь тус улсын үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулж, цаашилбал улс төрчдийг өнөөдрийн Оюу толгой, Таван толгой, үүнийг тойрсон Монгол Улсын үсрэнгүй хөгжлийн тухай дэврүүн ярихад хүргэсэн нь үнэн юм.

Монгол Улс гурвалсан яриа хэлэлцээний байнгын институцитэй болох нь хөрш хоёр гүрний бодлого, байр суурийг илүү тодорхой ойлгож мэдэх, өөрийн улсын бодлого, байр суурийг тайлбарлаж дэмжлэг авахад нэн ач холбогдолтой. Хөрш гурван улсын ГХЯ-д хоорондын 8 дахь удаагийн зөвлөлдөх уулзалт Улс төрийн газрын захирал нарын түвшинд 2012 оны 10 дугаар сард Москва хотноо болов. Анх удаагаа албан ёсны статустайгаар болсон гурван талын зөвлөлдөх уулзалт уул уурхайн салбар, дамжин өнгөрөх тээврийн гурван улсын нөөцийг хамтран ашиглах, дэд бүтцийн бүтээн байгуулалт, аялал жуулчлал, байгаль орчин, хүмүүнлэгийн солилцоо зэргийг талуудын харилцан сонирхолд нийцсэн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл хэмээн тэмдэглэжээ. Үүн дээр хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилсан дипломат ажиллагаа, хямралын менежментийн асуудлыг нэмж оруулах нь зүйтэй. 2013 оны 10 дугаар сарын 25-нд Бээжинд хоёр улсын Ерөнхий сайд нарын гарын үсэг зурсан «Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр»-ийн Тавын 5-д заахдаа: “Талууд Монгол, Хятад, Оросын гурван талын зөвлөлдөх уулзалтын механизмыг үргэлжлүүлэн бэхжүүлэх, дэд сайдын түвшний зөвлөлдөх уулзалтын механизмыг байгуулах асуудлыг урагшлуулахаар санал нэгтэй тохиролцов. Шаардлагатай тохиолдолд гурван талын өндөр түвшний уулзалт зохион байгуулж, Монгол, Хятад, Орос гурван улсын хамтын ажиллагааг улам бүр урагшлуулна”² гэж заасан нь чухал ач холбогдолтой.

2. Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх Дунд, Урт хугацааны Хөтөлбөр. УБ.: 2013.10.25

Цаашилбал хөрш гурван улсын Гадаад харилцааны сайд нарын уулзалт нэн чухал бөгөөд аажмаар АСЕАН+3 шиг гурван талын дээд уулзалтыг зохион байгуулж байнгын институци буй болгох чиглэлээр ажиллах шаардлага буй. Мөн Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлогын тухайд хоёр хөршөөр албан ёсны дэмжлэг авах явдал ч чухал байгааг онцлон тэмдэглэе.

Хөгжиж буй далайд гарцгүй орон дамжин өнгөрөх тээвэртэй холбогдсон асуудлуудыг олон улсын эрхзүйгээр хэрхэн зохицуулж чадахаас олон улсын эдийн засгийн харилцаанд харьцангуй давуу талаа ашиглан оролцох боломж шууд шалтгаалдаг. Тэдгээр улсууд дамжин өнгөрөх тээврээс гадна экспортын ихэнх нь түүхий эд, тэдгээр нь овор ихтэй байх, цаг агаарын таатай бус нөхцөл, хүн амын төвлөрөлт бага байдаг зэрэг олон бэрхшээлтэй тулгардаг. Монгол орны хувьд тээвэрлэлт болон даатгалын төлбөрт нийт экспортынхоо 20 хувьтай тэнцэхүйц зардал гаргадгыг 1999 онд ЮНКТАД-аас хийсэн судалгаа харуулсан бөгөөд энэ нь ДНБ-ний 8 хувьтай тэнцэж байв. Энэ бүхэн нь олон талт худалдааны тогтолцоонд бүрэн нэгдэх, түүний давуу талыг эдлэх талаар тавьж буй Монгол Улсын хүчин чармайлтад саад болсоор байна.

ЮНКТАД-ын дэмжлэгээр 2000 оноос Монгол Улсыг ОХУ, БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин далайн гарцад хүрэх, хөнгөлөлттэй нөхцлөөр дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэх чиглэлээр 3 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах уулзалт 7 удаа зохион байгуулаад байгаа боловч дорвитой ахиц өнөөг хүртэл гарсангүй.

Олон жилийн хүчин чармайлтын үр дүнд 2011 оны 12 дугаар сард ОХУ ДХБ-д гишүүнээр элсэх асуудал *de facto* шийдвэрлэгдэж, 2012 оны 8 дугаар сараас тус байгууллагын бүрэн эрхт гишүүн болсон нь дурдсан чиглэлд чухал ач холбогдолтой. ОХУ ДХБ-д гишүүнээр элссэнээр худалдаатай холбоотой дамжин өнгөрөх тээвэрлэлтийн хөнгөлөлтийн асуудлаар ч үүрэг хүлээх учиртай. Өнөөг хүртэл Монгол-ОХУ-ын хооронд худалдааны ерөнхий хэлэлцээргүй явж ирсэн нь ялангуяа түлш, шатахууны импортын үнэд нөлөөлсөөр ирэв.

Өөр нэг анхаарах зүйл бол Монгол Улс уул уурхайн түүхий эдийн бүтээгдэхүүнд экспортын гаалийн татвар оногдуулах асуудлыг зохистойгоор шийдвэрлэх шаардлагатай. ОХУ газрын тос болон бусад түүхий эдийн бүтээгдэхүүний экспортын гаалийн өндөр татвартай орон билээ.

2012-13 онд БНХАУ-ын нам, төрийн дээд удирдлагын хоёр таван жилийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж солигдов. Хятадын тав дахь үеийн шинэ удирдагч Си Жинпин БНХАУ-ын Дэд Ерөнхийлөгчөөр томилогдсоныхаа дараа 2008 оны 6 дугаар сард гадаад орнуудад хийх анхны айлчлалаа Монгол Улсаас эхэлж байсныг онцлон тэмдэглэе. Хятадууд хөршүүдээ баян, амгалан, сайн гэж гурав хуваасан байх агаад Япон,

БНСУ нь баян хөршүүд бол Монгол Улс нь сайн хөршид багтдаг ажээ. Хятад улс эрчим хүчний том хэрэглэгчийн хувьд Монголын нүүрс болон бусад байгалийн түүхий эдийг ихээхэн сонирхож буй нь тодорхой. Гэхдээ БНХАУ-д сонголт байгааг анхаарах хэрэгтэй. 2013 онд БНХАУ-ын эдийн засаг сэргэж, тогтвортой хөгжих төлөв ажиглагдаж байгаа нь Монгол Улсад үлэмж таатай нөлөө үзүүлнэ.

БНХАУ-ын удирдагч Ху Жиньтао 2012 оны 11 дүгээр сард хуралдсан ХКН-ын ХҮШ их хурал дээр тавьсан илтгэлдээ онцлохдоо: Хятад улс 100 жилийн ойгоор буюу 2049 он гэхэд баян чинээлэг, хүчирхэг, ардчилсан, соёл иргэншил бүхий төгс шинэчлэгдсэн социалист улс болно гэдгийг зарлав. Тэрбээр Хятад «дэлхий дээрх хамгийн том хөгжиж буй орон» хэмээн дүгнэв.

Монгол Улс, ОХУ-ын холбоотны харилцаа үгүй болж, шинээр стратегийн түншлэлийн харилцааг тогтоосон хэдий ч Монголын «буфер улс»-ын гүйцэтгэдэг геополитикийн үүрэг хэвээр, нөгөө талд ХХI зуунд өмнөд хөршийн эдийн засаг үсрэнгүй хөгжих болсон нь сайхь улс геополитик, гео-эдийн засгийн нөлөөний хүрээгээ өргөжүүлэн тэлж буйг Өрнөдийн судлаачид Хятадын «аюул» хэмээн нэрлэдэг нь ч ор үндэслэлгүй зүйл биш юм. Гэхдээ өөр нэг хүчин зүйл бол БНХАУ-ын эдийн засгийн хурдацтай хөгжил, тогтвортой байдал, хамгийн ойрын гадаад орчин ОХУ-БНХАУ-ын харилцаа хэвийн болж, итгэлцэл нэмэгдэж, стратегийн түншлэлийн түвшинд хүрсэн нь Монгол Улсын хөгжил дэвшил, үндэсний аюулгүй байдалд таатай нөхцлийг бүрдүүлж байна. Энэхүү таатай эерэг нөлөөг үгүйсгэж үл болно.

Түүнчлэн хоёр хөрш ОХУ, БНХАУ стратегийн түншлэлийн түвшинд харилцаагаа өргөжүүлж, БРИКС болон ШХАБ-ын хүрээнд улам бүр нягт хамтран ажиллах болов. Эрчим хүч, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаанд Монгол Улсыг «үл оролцуулах» бодлого баримтлах хандлагатай байгаа нь анхаарал татсаар байна.

Монгол Улсын гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангаж, залгамж чанарыг тууштай хадгалах явдал нэн чухал билээ. Хоёр хөрштэй харилцах гадаад бодлогын тэргүүлэх чиг шугамыг умартах, уламжлалт түнш, найрсаг харилцааны түвшинг үгүйсгэх, хоёр хөршид болж буй томоохон үйл явдал, дээд уулзалтын талаар үл ойшоосон болчимгүй байр суурь баримтлах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд таатай нөлөө үзүүлэхгүй нь ойлгомжтой.

1990-ээд оны эхнээс Монгол Улсын гадаад бодлогод «гуравдагч хөрш»-ийн үзэл санаа буй болж, улмаар 2010, 2011 онд шинэчлэн баталсан «Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал», «Гадаад бодлогын үзэл баримтлал»-д «гуравдагч хөрш»-ийн бодлогыг зүйлчлэн зааснаар тухайлсан албан ёсны төрийн бодлого хийгээд онол-үйл ажиллагааны түвшний судалгааны шинэ чиглэл болов.

1994 онд батлагдсан Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд «гуравдагч хөрш» хийгээд «гуравдагч хөрш»-ийн бодлого, түншлэлийн талаар тусгайлан заагаагүй боловч “Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-д анх удаа **«Европын Холбоотой иж бүрэн түншлэлийн түвшинд харилцах бодлого баримтлана»**³, 2010 онд шинэчлэн батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д **«“Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ»**⁴, харин 2011 онд шинэчлэн батлагдсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д «АНУ, Япон, Европын Холбоо... зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх»⁵-ээр анх удаа бодлогын хэмжээнд тус тус заажээ. Харин шинэчлэн батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д Холбооны [Европын] талаар заагаагүй байна. Үзэл баримтлалаас харахад Монгол Улсын «гуравдагч хөрш» гэдэгт нэгд, өндөр хөгжилтэй, хоёрт, ардчилсан улс, холбоо гэж ойлгогдож байгаа юм. «Гуравдагч хөрш»-ийн бодлогын хүрээ гэдэгт улс төр, аюулгүй байдал, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг хэлж байна. Бидний хувьд Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийг илүү өргөн утгаар нь авч үзвэл нийт хүн төрөлхтний өмнө тулгамдсан глобал асуудлыг авч хэлэлцдэг, энхтайван, аюулгүй байдлыг сахин хангах зорилготой дэлхийн хамтын нийгэмлэг НҮБ ч орох учиртай. НҮБ бол хөгжиж буй улс орнуудын нийтлэг эрх ашгийг илэрхийлдэг, мөн хамгаалдаг, Монгол Улс ч тэр, АНУ ч хоёул адилхан нэг, нэг саналтай ийм түгээмэл байгууллага болой.

Монгол Улс өөрийн хүрээлэн буй геополитикийн орчинд «гуравдагч хөрш»-тэй болж, түүний эрхзүйн үндсийг бүрдүүлсэн гэж дүгнэж болохоор байна. Монгол Улс 1997 онд Японтой «Иж бүрэн түншлэл», 2010 онд «Стратегийн түншлэл», 1999 онд БНСУ-тай «Харилцан нөхсөн хамтын ажиллагаа, хөгжлийн түншлэл», 2006 онд «Сайн хөршийн найрамдал, хамтын ажиллагааны түншлэл», 2011 онд «Иж бүрэн түншлэл», 2004 онд Канадтай «Өргөн хүрээтэй түншлэл», 2005 онд Турк улстай «Иж бүрэн түншлэл», 2004, 2005 онд АНУ-тай «Стратегийн түншлэл», 2007 онд Австрали улстай «Өргөтгөсөн түншлэл», 2007 онд Казахстантай «Өргөн хүрээтэй түншлэл», 2008 онд ХБНГУ-тай «Иж бүрэн түншлэл», 2009 онд Энэтхэгтэй «Иж бүрэн түншлэл», 2011 онд Украинтай «Олон талтай хамтын ажиллагааны түншлэл»-ийн харилцааны эрхзүйн баримт бичгүүдийг тус тус байгуулав.

3. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого. УБ., 2008, 119 дэх тал

4. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010

5. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. УБ., 2011

Европын Холбоотой «Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр» байгуулах цуврал яриа хэлэлцээ 2009 оны 9 дүгээр сард эхэлж, 2010 оны 12 дугаар сард хоёр тал хэлэлцээрийг үзэглэв. Монгол Улс АОХН-ийг даргалж буй орны хувьд Сайд нарын YII чуулга уулзалтыг 2013 оны 4 дүгээр сарын 27-29-нд Улаанбаатар хотноо анх удаа зохион байгуулав. Энэхүү арга хэмжээнд оролцсон Еврокомиссын Дэд Ерөнхийлөгч, ЕХ-ны Гадаад бодлого, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн Дээд Төлөөлөгч К.Аштон 2013 оны 4 дүгээр сарын 30-нд Гадаад харилцаан сайд Лу.Болдтой ГХЯ-нд хэлэлцээ хийж, «Монгол Улс, Европн Холбооны Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр»-т гарын үсэг зурав. Бүр 1995 онд Өрнөд Европын орнуудаас анх удаа Европын Холбооны жинтэй, нөлөө бүхий гишүүн, ХБНГУ-тай «Монгол Улс, ХБНГУ-ын харилцааны үндсийн тухай Тунхаглал», 1996 онд Францтай «Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны хэлэлцээр», Австрали улстай «Найрамдал, хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл»-ийг анх удаа байгуулсан нь нэн ач холбогдолтой үйл явдал байв.

2011 оны 8 дугаар сард Финляндын Ерөнхийлөгч хатагтай Тарья Халонен Монгол Улсад айлчлах үеэрээ хоёр орны харилцаа нь «тэгш эрхтэй түншлэл»-ийн харилцаа мөн хэмээн тэмдэглэсэн байдаг.

Лалын ертөнцийн орон зайн концентраци Казахстанд шилжих үйл явц ажиглагдаж, Төв Азид тус улсын байр суурь, нөлөө идэвхжих болов. Азид хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх Зөвлөлгөөнийг (Conference on Interaction and Confidence-Building Measures in Asia-CICA) Казахстаны Ерөнхийлөгч Нурсултан Назараев анхлан санаачилж эдүгээ энэ байгууллага бүс нутгийн аюулгүй байдлын асуудлыг хэлэлцдэг олон талт хамтын ажиллагааны нэг болов. ЕАБХАБ-ын дээд уулзалт 1999 онд Стамбул хотноо чуулснаас хойш 11 жилийн дараа тус байгууллагыг 2010 онд тэргүүлсэн Казахстан улс өөрийн оронд анх удаагаа үр дүнтэй зохион байгуулж, Ираны цөмийн хөтөлбөрийн асуудлаар 5+1 бүлгийн уулзалтыг Казахстан улс 2013 оны 4 дүгээр сард Алматы хотноо амжилттай зохион байгуулсан зэрэг нь дээрхийн нотолгоо юм.

ШХАБ хэмээх бүс нутгийн хамтын ажиллагааны бүтэц буй болж, цаашдаа НАТО, голлон АНУ-ын Еврази дахь нөлөөллийг бууруулах зорилго бүхий цэрэг, улс төрийн эвсэл болж төлөвших магадлал ажиглагдсаар байна. Гэхдээ энэ байгууллагын ирээдүйн дүр төрх бүрхэг байгааг тэмдэглэх хэрэгтэй. Геополитикийн талаас авч үзвэл Монгол Улс энэ байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд оролцож байх шаардлага бий. Нөгөө талд хоёр хөрш улсын оролцоо давамгайлсан эл байгууллагад гишүүнчлэлтэй болох нь Монгол Улсын үндэсний эрх ашигт нийцэхгүй юм. Хоёр хөрш Монголыг гишүүнчлэлтэй болгох сонирхол ажиглагддаг ч ШХАБ-ын хүрээнд яригддаг худалдаа-эдийн засаг, эрчим хүч, авто болон төмөр замын томоохон төслүүд нь ажиглагч гишүүн улсын хувьд хаалттай байдаг.

Сүүлийн үед энэ байгууллагыг цэрэг-улс төр, аюулгүй байдлын гол институци болгох гэсэн ОХУ-ын оролдлого нь ШХАБ-аар дамжин Төв Ази дахь эдийн засгийн ашиг сонирхлоо бэхжүүлэх гэсэн Хятадын байр суурьтай зөрчилдөх төлөв ажиглагдах болов.

Тиймээс Монгол Улсын энэ байгууллагад ажиглагчийн статустай байгаа нь хангалттай ч Монгол Улс өөрийн эрх ашигт нийцсэн оролцооны өөр гарцыг буй болгох талаар идэвхтэй ажиглах, ажиллахад хүргэж байна.

2006 оны 9 дүгээр сарын 8-нд Казахстаны Семипалатинскийн цөмийн туршилтын талбайд гарын үсэг зурсан «Төв Азийн цөмийн зэвсэггүй бүсийн тухай гэрээ» 2009 оны 3 дугаар сарын 21-нд хүчин төгөлдөр болж, 2012 оны 5 дугаар сарын 3-нд Вена дахь Олон улсын атомын эрчим хүчний агентлаг дээрх гэрээг бүртгэж авсан нь Монгол Улсын хувьд чухал ач холбогдолтой болов.

P5 гэж нэрлэгддэг НҮБ-ын АЗ-ийн Байнгын тав буюу цөмийн зэвсэгтэй таван гүрний Байнгын төлөөлөгчид болон Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч О.Оч нар «Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид статусын талаарх Хамтарсан Тунхаглал», энэ статусын агуулгыг тодорхойлсон Тунхаглалд 2012 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр Нью Йорк хотноо нэгэн зэрэг гарын үсэг зурав. Цөмийн зэвсгээс ангид Монгол Улсын статусын талаарх P5-ын хамтарсан тунхаглал болон Монгол Улсын тунхаглал нь дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсан, цөмийн зэвсэгтэй гүрнүүд цөмийн зэвсэггүй орнуудтай хэрхэн хамтран ажиллах боломжтойг харуулсан, цөмийн зэвсгийг хорогдуулах үйлсэд хувь нэмэр оруулж байгаагаараа нэн ач холбогдолтой юм. P5-ын гаргасан хамтарсан тунхаглалд Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусын тухай хуулийг сайшаасныг анх удаага албан ёсоор мэдэгдэж, Монгол Улсын статусыг хүндэтгэж, түүнийг зөрчих аливаа үйл ажиллагаанд оролцохгүй, тийм үйл ажиллагаа явуулахгүй байх амлалтыг Монголын талын саналаар тунхаглалд тусгасан байна. P5 Монголын энэхүү өвөрмөц статусыг бүрэн хүлээн зөвшөөрөн хүндэтгэж, түүнийг зөрчих аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх амлалт авсан нь улс төрийн нэн чухал ач холбогдолтой үйл явдал болсноос гадна P5 тодорхой асуудлаар нэгдмэл байр суурьтай байгаага дэлхий дахинд харуулсан нь ч чухал болсныг тус арга хэмжээнд оролцсон НҮБ-ын ЕНБД-ын орлогч Ян Эльясон (Jan Eliasson) тэмдэглэв.

Монгол Улсаас санаачлан 2012 оны НҮБ-ын ЕА-н 67 дугаар чуулганд өргөн барьсан «Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус» тогтоолын төслийг чуулганы улс төр, аюулгүй байдлын асуудлаарх 1 дүгээр хорооны 11 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, нийтийн зөвшилцлөөр, санал хураалтгүйгээр баталжээ. Дээрх мэдэгдлийг сайхь тогтоолд сайшаасан нь нэн чухал ач холбогдолтой болов.

Монгол Улсаас санаачилсан тогтоолыг Австрали, АНУ, Их Британи, БНХАУ, ОХУ, Франц, Мексик, Морокко улс хамтран зохиогчоор оролцсон байна.

Монгол Улсын энэхүү туршлага Солонгосын хойгийг ирээдүйд цөмийн зэвсгээс ангид бүс болгох хэрэгт парадигм болох боломж байгааг онцлон тэмдэглэмээр байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал нь Зүүн хойд Азийн дэд бүс нутгийн аюулгүй байдлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн. Зүүн хойд Азийн «зүрхэн газар» Солонгосын хойгийн аюулгүй байдал Монгол Улсад шууд нөлөөлөхөөр байна. Солонгосын хойгийн намжмал байдал хурцаахад Өмнөд Солонгост ажиллаж, сурч, амьдарч буй 35 орчим мянган монгол иргэдийн аюулгүй байдлын асуудал шууд хөндөгдөж байгаа билээ. Зөвхөн тэдгээр иргэд жилд дунджаар 200-250 сая ам. долларыг Монгол Улс руу шилжүүлдэг гэж тооцож үзэхэд ямар олон айл, гэр бүлийн амьдрал, бизнес, Монгол Улсын нийгэм-эдийн засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлж буй нь тодорхой. БНСУ нь Монгол Улсын худалдааны гуравдахь, хөрөнгө оруулалтын хамгийн ойрын түнш юм.

Монгол Улс БНСУ, БНАСАУ хоёрын аль алинтай нь «тэгш» сайн харилцаатай дэлхийн цөөхөн орны нэг бөгөөд Хойд Солонгосын цөмийн хөтөлбөр, хоёр Солонгосын эвлэрэл, цаашдын нэгдэх үйл явцад өөрийн хувь нэмрийг оруулах, тодорхой үүрэг гүйцэтгэх боломж байгаад анхаарлаа хандуулсар ирэв.

2012 оны 11 дүгээр сарын 21-нд ЕАБХАБ-ыг тэргүүлсэн Ирланд улсын Ерөнхий сайдын орлогч бөгөөд Гадаад хэрэг, худалдааны сайд Эамон Гилмор (Eamon Gilmore) дээрх байгууллагын 57 дахь гишүүнээр Монгол Улсыг элсүүлэхээр шийдвэрлэснийг албан ёсоор мэдэгдэж, 12 дугаар сарын 6-7-нд Дублинд болсон ЕАБХАБ-ын гишүүн орнуудын Гадаад харилцааны сайд нарын Зөвлөлийн 19 дахь уулзалтад Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Болд анх удаа оролцож «Шинэ Европын Парисын Харти»-д нэгдэн орж, ЕАБХАБ-ын бүрэн эрхт гишүүн болсны хувьд анх удаа үг хэлэв. Ийнхүү Монгол Улс бүс нутгийн аюулгүй байдлын хүчирхэг байгууллагын гишүүнээр элссэн анхны Дорно дахины орон болов. Ийнхүү ЕАБХАБ нь Атлантик, Газрын дундад тэнгис, Евразийг дамнасан өөрөөр хэлбэл Ванкуверээс Владивосток хүртэл аюулгүй, тогтвортой байдлыг хангах чухал механизм болон хөгжиж, үйл ажиллагаа нь өргөжсөөр байна. Монгол Улс үндэсний аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангах зорилтыг хэрэгжүүлэхэд ЕАБХАБ-тай тогтоосон харилцаа чухал ач холбогдолтой нь тодорхой байна.

Монгол Улс ЗХА-ийн бүх орнуудтай хоёр талын түвшинд стратегийн болон иж бүрэн түншлэл, найрсаг харилцаа, хамтын ажиллагааны эрхзүйн үндсийг тавьсан цорын гагц орон гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Бүс

нутгийн орнуудтай ямарваа нэгэн ноцтой зөрчил маргаан, тэгэх тусмаа улс төрийн санал зөрөлдөөн байхгүй байгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын чухал ололт мөн.

Геополитикийн дотоод орчны дүн шинжилгээ: сөрөг хувьсал

Монгол Улс дэлхийд хамгийн том газар нутагтай, мөн хамгийн олон хүн амтай хоёр гүрний дунд оршдог, үүгээрээ цорын ганц гэж хэлж болохоор, түүнчлэн далайд гарцгүй, дэлхийн зах зээлээс алслагдмал, хөгжлийн тусламж горилогч, буурай хөгжилтэй орон байсан бол эдүгээ хоёр аварга зааны дунд орших шандаст хүлэг (galloper) гэж хэлж болохоор, өөрөөр хэлбэл дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй бүс нутагт орших болж, эрдэс баялаг, түүхий эд, эрчим хүчний үлэмж нөөцтэй нь тодорхой болсон нь олон улсын анхаарал, их гүрнүүдийн болон үндэстэн дамнасан бизнес бүлэглэлүүдийн геополитик, геоэдийн засгийн ашиг сонирхлыг эрхгүй татаж, энэ нь томоохон шинэ боломж, түүнчлэн томоохон шинэ эрсдлийг дагуулж байна. Монгол Улсыг хоёр гүрний хооронд хавчуулагдсан «халиуны зулзага» (sandwich), бага жижиг улс, дэлхийн зах зээлээс алслагдсан, хөгжлийн тусламж горилогч гэх мэтээр нэрлэж байсан геополитикийн томъёолол үндсэндээ хуучрав.

Монгол Улсын 1.3 их наяд ам. долларын өртөг бүхий байгалийн баялаг, уул уурхайн салбар юуны өмнө анхаарлын төвд орж ирлээ. Байгалийн баялгийн үр шимээс ард иргэд нь тэгш хүртэж чадахгүй, цаашлаад эко орчин нь тэнцвэрээ алдах, зэвсэгт мөргөлдөөн, эрх мэдэл, авлигын гол шалтгаан болж, тиймээс ч баялгийн хараал буюу natural resource curse болдгийг буурай хөгжилтэй орнуудын сургамж харуулдаг ажгуу. Хэт ашгийн хойноос улайрагч гадны үндэстэн дамнасан хөрөнгө оруулагчдын хүсэл сонирхол, мөн ч олон улсын банк, санхүүгийн байгууллагын заавар зөвлөмж, их гүрнүүдийн нөлөө ивээл үндэсний шинээр төрж буй баяжих нэн сонирхолтой хөрөнгөлөг этгээдүүд (мөн улс төрчид) хоёрын нийлбэрийг «эдийн засгийн алуурчид» буюу economic hit men хэмээн нэрлэх болсон нь онход оргүй зүйл биш юм. Тиймээс ч «гуравдагч хөрш»-ийн бодлогын хүрээнд үүнийг сайтар харгалзан үзэх шаардлагатай болов.

«Гуравдагч хөрш»-бодлогын хүрээнд Өрнө, Дорны хөгжингүй, ардчилсан орнуудын Монгол дахь эдийн засгийн бодит сонирхолыг буй болгох чиг шугам тодорхой сорилтуудтай тулгарч байна. Үүнийг Лондонд бүртгэлтэй АНУ-ын «Soko International PLC» компани Тамсагийн сав газарт газрын тосны хайгуул үнэлгээний ажил явуулахаар Монгол Улсын Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан ч тодорхой үр дүнд хүрсний дараа ашиглалтын лицензийг 2005 онд Хятадын төрийн өмчийн «Петро Чайна Дачин Тамсаг [Монгол]» компанид худалдсан байна. Цаашилбал Канадын Ванкувер хотноо бүртгэлтэй «Western Prospector Group Ltd», мөн Торонто

хотод бүртгэлтэй «Khan Resources Inc.» Торонто, Нью-Йоркт бүртгэлтэй «SouthGobi Resources Ltd.» (толгой компани нь «Turquoise Hill Resources Ltd» буюу хуучнаар «Iyanhoe Mines Ltd»)-ийн салбар компани болох British Yirginia-д бүртгэлтэй «SouthGobi Sands LLC», Лондон, Мельбурн хотноо бүртгэлтэй Британи-Австралийн үндэстэн дамнасан корпораци «Rio Tinto Group»-ийн явуулж буй үйл ажиллагааг энд тэмдэглэх хэрэгтэй.

Гэхдээ зарим улс төрчдийн хэлж буйчлан дээрх баримт нь Монгол Улсын «гуравдагч хөрш»-бодлогын нуралт биш бөгөөд «гуравдагч хөрш»-бодлогын улс төрийн чиглэл нь тодорхойлогч шинжтэй гэдгийг онцлон тэмдэглэе.

Ойрмогхон хугацаанд уул уурхайд түшиглэсэн үсрэнгүй хөгжлийн их тэсрэлт (big bang) болоод өнгөрөв. 2011 онд Монгол Улсын ДНБ (ҮНО)-ий өсөлт бараг 18 хувьд хүрсэн нь дэлхийд байхгүй цорын ганц (singularity) үзүүлэлт болов. Үүнийг Монголын гайхамшиг (miracle) төдийгүй дэлхийн эдийн засгийн хөгжлийн phenomena хэмээн нэрлэж байв. 2011 оны 7 дугаар сард Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхийлөгч Эрхэмсэг хатагтай Прагибха Девисингх Патил Монгол Улсад айлчлах үеэр Монгол Улсын эдийн засгийн өсөлт ирэх 2012 онд 26 хувиар өсөхөөр байгааг монголчуудаас дуулснаа гайхан биширч байсан юм.

Харин бага зэрэг саарсан ч Хятадын эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн эрэлт хэрэгцээ дэлхийн байгалийн баялаг, түүхийг эдийг сорогч их тэсрэлт black hole (асар их хүчтэй сансарын ховх сорогч үл мэдэгдэх хар нүх зохиогч) хэвээр байгаа юм. Дэлхийн санхүү, эдийн засаг, гол нь ЕХ-ны төсөв, өрийн хямралтай холбоотой Хятадын эдийн засгийн өсөлт 7 хувь хүртэл буурсан ч Монголын эдийн хөгжилд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй болно. 2012 оны сүүлчээс Монголын эдийн засгийн өсөлт 10 хувь руу доошилж, гадаадын хөрөнгө оруулалт 2010 онд 1.6, 2011 онд 4.6, 2012 онд 3.8 тэрбум ам. доллар болж, 2013 онд 42 хувиар буурсан нь Монгол Улсын дотоодын хууль эрхзүйн орчны тогтворгүй, ойлгомжгүй байдал, Засгийн газрын улс төр, эдийн засгийн бодлого, байр сууринаас илүү шалтгаалсан хэмээн судлаачид үзэж байгаа нь үнэн юм.

ОУВС-гийн үзүүлэлтээр 2000 онд Монгол Улсын ДНБ 1.1 тэрбум ам. доллар байсан бол 2012 онд 15.1 тэрбум ам. доллар болж 15 дахин өссөн байхад цалин, тэтгэвэр, тэтгэмж мөнхүү тэр хэмжээгээр өссөнгүй.

2012 оны 11 дүгээр сард Монгол Улсын Засгийн газар олон улсын хөрөнгийн бирж дээр бонд гаргаж 1.5 тэрбум ам. долларыг богино хугацаанд амжилттай босгосон⁶ хэдий ч энэ их хөрөнгө шууд хөрөнгө оруулалт болж чадаагүйн улмаас олон сая ам. доллартай тэнцэх боломж, цаг хугацааг алдав. Засгийн газар Төвбанктай санхүүгийн зуучлалын гэрээ байгуулсны

6. 2012 оны хавар Хөгжлийн банк 600 сая ам. долларын бонд босгож, үүний хүүд 22 тэрбум төгрөгийг төлж байсан юм.

дагуу “Чингис” бондын менежментийг хийж байгаа гэж тайлбарласан боловч тодорхойгүй байдал үргэлжилсэн юм. 2013 оны 3 дугаар сарын 26-нд ОУВС болон Bloomberg Монгол Улсын алтны нөөц 2008 оны 8 дугаар сард 1.5 тонн байснаас 3.8 дахин өссөн тухай мэдээлсэн нь бондын мөнгөөр алт худалдаж авсан байж болзошгүй таамаглалыг төрүүлсэн бөгөөд үүнтэй зэрэгцэн Лондоны үнэт металын бирж дээр унц алтны үнэ огцом унаж 1395.00 ам. доллар хүртэл буурсан нь үлэмж алдагдал хүлээхэд хүрч болзошгүй үндэслэл байв.

2013 оны 6 дугаар сараас дээрх өрийн бичгийн хагас жилийн хүүгийн төлбөрт 35.85 ам. долларыг (жилийн хүүд 75 орчим сая ам. доллар, жилд хүү 108 тэрбум төгрөг, \$1:₮1440) төлж эхлэв. Одоогийн тандалтаар Засгийн газар олон улсын хөрөнгийн зах зээл дээр дахин томоохон бонд гаргаж мөнгө босгох асуудал ул суурьтай судалгаа, дүн шинжилгээ, эрсдлийн үнэлгээ хийж, сайн боловсруулсан техник-эдийн засгийн үндэслэлтэй төслийн бэлэн байдалд онцгой анхаарах шаардлагыг буй болгов. Анхаарал татаж буй ноцтой асуудал бол 2013 оны 4 дүгээр сарын 16-нд олон улсын зээлийн зэрэглэл, хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ, үнэлгээ хийдэг санхүүгийн Standart & Poog’s LLC компани Монгол Улсын зээлжих зэрэглэлийн «ВВ тогтвортой» гэсэн үзүүлэлтийг «ВВ сөрөг» буюу «эрсдэлтэй» болгож бууруулсан. Томоохон бүтээн байгуулалтын үйл ажиллагаа эхлэх цаг үед ийм үнэлгээ авсан нь тийм таатай зүйл биш гэдэг нь ойлгомжтой. Засгийн газар бондын бодлогын зөвлөл хэмээх бүтэц буй болгосон нь УИХ-ын бүрэн эрхт халдаж байгаа хэрэг мөн. Японы хөрөнгийн бирж дээр 500 сая ам. долларын самурай бонд гаргах асуудал гадаад өрийн менежменттэй шууд холбогдоно.

Гадаад өр 15.2 их наяд төгрөгт хүрч, энэ нь зөвхөн өнгөрсөн таван жилд хуримтлагдсан байна. Хувийн хэвшлийн өр улсын өрөөс давамгайлах хандлага ажиглагдаж байгаа талаар шинжээчид анхааруулж байна. Гадаад өр 40 хувийн босгыг давж, ДНБ-ын 48.5 хувь болж байна. Ийм байхад гадаад өрийг ДНБ-ний 60 хувьд хүргэх санал гарч ирж байгаад нухацтай хандах шаардлагатай. Гадаад валютын нөөц ч 1 тэрбум ам. доллар болж буурав.

Үнэт цаас, өрийн бичгээс орж ирсэн хөрөнгө мөнгийг УИХ-аар батлуулалгүй дур мэдэн төсвийн гадуур зарцуулж, Монгол Улс улсын төсөв, хөгжлийн банкны төсөв, бондын төсөв гурван төсөвтэй болчихлоо. Чингис бондын хөрөнгийг улсын төсөвт суулгахгүй хууль зөрчиж байгаа атлаа өрийн хүүгийн төлбөрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байгаа нь үнэхээр ноцтой.

УИХ-ын удирдлагын явцуу менежментийн үрээр, сөрөг хүчний оролцоогүй 2013 оны төсвийн орлогыг хэтэрхий дэврүүн байдлаар тусгаж батлажээ. Төсвийг зохиохдоо орлогоо эдийн засгийн өсөлтөөс бараг хоёр дахин илүү төлөвлөж, эдийн засгийн шинжлэх ухаанд суурилагүй бодлого

явуулсан, ямар ч мэдлэггүй Ерөнхий сайдын “Эрдэнэс Таван толгой” төсөл дампуурсан хэмээн сүржин хийсэн мэдэгдлүүд улс орны хөгжилд тус болсонгүй.

Үндсэн шалтгаан нь тодорхойгүйгээр төгрөгийн ханш унаж, 1700 төгрөгт хүрсэн нь үнийн өсөлтөд голлон нөлөөлж, инфляци хоёр орон тоонд тулж ирэв. Халамжийн мөнгөнөөс болж л өргөн хэрэглээний барааны үнэ өсдөг гэсэн нь үндэслэлгүй болж байна.

Эзнээ олоогүй хавтгайрсан амлалтын бодлого, төрийн нүсэр институцийн зардал төсвийн алдагдлыг гааруулж, улс орныг эдийн засгийг гүн хямралд түлхдэгийг ЕХ-ны гишүүн нилээд орны хүндрэл бидэнд сануулсаар буй. Өндөр хүүтэй зээлээр тараасан, ирээдүйд улсын өр болох 21 мянган төгрөг бол амлалтын мөнгө болохоос халамжийн мөнгө биш байсан юм. Гэхдээ энэ мөнгө олон мянган өрхийн амьжиргаа, ЖДҮ-ийн борлуулалтад чухал нөлөө үзүүлснийг нотлох шаардлагагүй. Амлалтын мөнгийг хүүхдийн мөнгөтэй нэг болгосон нь хамтарсан Засгийн газрын арчаагүй үйлдэл, том нүгэл болсон. Сурлагын хөшүүрэг байж, 80 түүнээс дээш үнэлгээтэй оюутнуудад тэтгэлэг болж очвол сайхь 70 мянган төгрөг илүү үр дүнтэй байх атал хавтгайруулсан нь аанай л шинэ баян цээж өвчтэйн бэлэн жишээ байв. 21 мянган төгрөгийн үнэ цэнэ үнийн хөөрөгдөл, инфляцитайгаа хамт замхарсан. 2008 оны сонгуулийн дараа Засгийн газраа дангаараа байгуулсан бол 1.5 сая, харин амлалтаа биелүүлэхээр хамтарсан Засгийн газар байгуулагдчихсан учир хоёр намын амлалтыг нэгтгээд хувьцаагаа ч, мөнгөө ч авах ёстой байв. Хэлсэн амандаа эзэн болох нь хар толгойгоо хариуцлагаас мултлах улс төрчдийн том “соёл” мөн. Гэтэл амлалтаа биелүүлж чадахгүй гэдгээ ичих ч үгүй мэдэгдсэн билээ. Хамтарсан Засгийн газар сонгуулийн бүрэн эрхийн хугацаандаа амлалтаа биелүүлсэн бол монголчууд бүгд «саятан» болох байв. Тиймээс ч хууран мэхэлж, залилан хийж засаг төрийн эрхэнд гарсан улс төрийн том намууд 2012 оны сонгуульд нэр дэвшүүлэх улс төр, ёс суртахууны эрхгүй тухай олон нийт ихээхэн шүүмжилтэй ярилцаж байсан юм. Нөгөө нэг зүйл нь халамжид олгож буй (хэрэг дээрээ энэ нь амлалтын мөнгө юм) асар их мөнгөний яриа гаргах болгонд иргэдийг бэлэнчлэх сэтгэлгээнд сургаж байна, энэ их мөнгөөр аж үйлдвэрийн цогцолбор барих байсан юм, төчнөөн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрөх газар барих бололцоотой байсан юм хэмээн хоосон сурталддаг. Хамгийн гол нь тийм том бүтээн байгуулалт хийгдээгүй бөгөөд хийгддэгүйд л асуудал нь байгаа билээ. Хамгийн сүүлийн жишээ бол ХУД-ийн Яармагт баригдаж ашиглалтад орох ёстой байсан 300 хүний ортой ГҮ төрөх газрын түүх болой.

Монголбанкны мөнгөний хаалттай бодлого, 1.5 тэрбум долларын бондын мөнгө орж ирчихээд байхад экспортын орлого буурч долларын хомсдол буй болсон гэж тайлбарлаж буй нь тун гайхал төрүүлж байгаа юм. Монголбанк 900 тэрбум төгрөг гүйлгээнд нэмж нийлүүлснээр цаасан мөнгөний зохих илүүдэл буй болж, Монгол Улсын голлон харьцдаг Хятад, ОХУ, БНСУ,

Японы эдийн засаг тогтвортой байхад нэг жилийн дотор Монголын эдийн засаг ноцтой саарч байгааг хүлээн зөвшөөрөх ёстой. 470 гаруй аж ахуйн нэгжийн тоо 50 хувиар буурав. 30 сая тонн нүүрс гаргана гэсэн ч 7-8 сая тонн л гаргав. 70 доллар байсан бол 56 ам доллар, тэгээд 40 орчим доллар болов. Оюунтолгойн далд уурхай түр хаагдав. Энэ нь төслийн 70 хувь нь юм. Импорт Хятадын бүрэн мэдэлд байхад юань 280 төгрөг болж өсөв. Хүний хөгжлийн сангийн мөнгө бондод тулгуурлах болов.

УИХ үнийн өсөлтийг бууруулах зорилгоор 2013 оны төсөвт Засгийн газарт 270 тэрбум төгрөг баталж өгсөн нь түүхэнд байгаагүй үйл явдал байсан боловч махны үнийг тууштай буулгаж чадсангүй инфляци хоёр оронтой тоогоор өсч, 10.4 хувьд хүрэв.

Монгол Улс 2012 онд 4.38 тэрбум ам. долларын бүтээгдэхүүн экспортод гаргаснаас 89 хувийг эрдэс бүтээгдэхүүн эзэлж, энэ нь Монгол Улсын ДНБ-ний 20 хувьтай тэнцэж байв. 2011 онд Монгол Улсын эрдэс баялгийн салбарт БНХАУ-ын төрийн өмчит болон хувийн корпорациуд 2.3 тэрбум ам. долларын хөрөнгө оруулалт хийж, тухайн салбарын томоохон хөрөнгө оруулагч болсон бөгөөд 2006 онтой харьцуулахад хөрөнгө оруулалтын хэмжээ 5 дахин өссөн байна. Монгол Улсын эрдэс баялгийн салбарт БНХАУ-ын оролцоо, нөлөө өсч байгаа нь монголчуудын байгалийн баялагтай холбоотой үндэсний үзлийг өөгшүүлэхэд ихээр нөлөөлж байгааг америкийн монголч эрдэмтэн Алиса Кэмп тэмдэглэснийг⁷ хүлээн зөвшөөрөх ёстой.

2012 онд Монгол Улс 20.9 сая тонн нүүрс, 574 мянган тонн зэсийн баяжмал, 6.4 сая тонн төмрийн хүдэр, 3 мянга 570 баррель түүхий газрын тос, 2.8 тонн боловсруулсан болон боловсруулаагүй алт, 140 мянган тонн цайрын баяжмал экспортложээ. Нийт экспортын 43.2 хувийг нүүрс, 19.1 хувийг зэсийн баяжмал, 12.1 хувийг төмрийн хүдэр эзэлж байв.⁸

Монгол Улсын нүүрсний экспорт БНХАУ, Монгол Улсын гаалийн статистикийн дүн мэдээнд бараг хагас сая тонноор зөрж байгаа нь далд эдийн засаг гүн оршиж байгаагийн тодорхой илрэл юм.

Оюу толгойн гэрээнд өөрчлөлт оруулах, Хятадын хөнгөн цагаан үйлдвэрлэгч төрийн өмчит «Чалько» компанитай байгуулсан гэрээгээ цуцлах Засгийн газрын шийдвэртэй уялдан «Эрдэнэс Таван толгой» төрийн өмчит компани нүүрсний нийлүүлэлтээ зогсоосон, стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялгийн төслүүдэд Монголын талын хувь оролцоог нэмэгдүүлэх байр сууриа илэрхийлсэн зэрэг нь гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг татсан нь ойлгомжтой. Хоёр компаниас авсан зээлийн өр МАН, АН хоёрын 2008 оны сонгуулийн гол амлалтаа хэрэгжүүлэх гэснээс үүдэлтэй.

2013 оны 4 дүгээр сарын 16-18-нд Лондонд өндөрлөсөн Монголын хөрөнгө оруулалтын чуулганы дараа гадаадынхны сонирхол мэдэгдэхүйц нэмэгдэх төлөвтэй байна. Энэ нь 2013 оны 4 дүгээр сарын 19-нд УИХ

7. Alicia Campi. «The Bumpy Path to Sino-Mongolian Cooperation in the Mining Sector». «China Brief» The Jamestown Foundation, Volume 3, February 1, 2013

8. Alicia Campi. «The Bumpy Path to Sino-Mongolian Cooperation in the Mining Sector».

«Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай» урт нэртэй хуульд зарим «засвар» оруулсантай холбоотой.

«Чалько» компанитай хийж буй хэлэлцээнээс үл хамааран Засгийн газар ямар ч гэсэн нүүрсний экспортоо 2013 оны 4 дүгээр сарын 22-ноос сэргээсэн боловч “Эрдэс Таван толгой” компаний тендертэй холбоотой асуудал Иргэдийн анхаарлын төвд гарч ирсэн билээ. 2013 оны төсөвт тусгаснаар Монголын Улсын Засгийн газар Хятадад 30 сая тонн нүүрс нэг тонныг нь 160 ам. доллараар гаргана гэж байсан боловч хүлээгдэж буй гүйцэтгэлээр 7-8 сая тонн л гаргахаар байна. Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 70 доллараар тохиролцсон гэрээний үнэ 56 ам доллар болтол буурч, бусад компаниуд 40 доллараар Хятадад нүүрс нийлүүлэх болов.

Хятадад кокс нийлүүлэх боломжтой цорын гагц улс нь Монгол биш⁹ гэдэг нь нэн тодорхой билээ. Өөрөөр хэлбэл юмтай нь гэдийдэг цаг үе аль хэдийнээ өнгөрчээ. 2012 оны 12 дугаар сард Хятадын Өрөмчи хотоос Киргиз, Узбекистанаар дамжин Казахстан, Оросын төмөр замтай холбох төмөр зам тавихаар шийдвэрлэв. Ингэхдээ хятадууд өөрийн нутаг дэвсгэрийн хил хүртэл тавих төмөр замын хэсгийг 15-20-ийн өргөн царигаар тавихаар болжээ.

Монгол Улс төмөр замын талаар баримтлах бодлогоо, гол нь царигийн асуудлаа нэг мөр болгож чадахгүй маргалдсаар үлэмж цаг хугацааг алдав.

9. Австралийн уул уурхайн томоохон «Celsius Coal Co.» (ASX: CLA) компани Киргизийн Узгень мужийн сав дагуу орших коксжих нүүрсний үлэмжхэн нөөцийн ордыг эзэмшдэг бөгөөд 2014-15 онд Хятад руу экспортлох бэлтгэл ажлаа үндсэнд нь дуусгаж байна. Тус компанийн эзэмшдэг коксжих нүүрсний Узгенийн ордын нөөц 250 сая тонн бөгөөд цаашид ч нэмэгдэх төлөвтэй байгаа ажээ. Узгенийн сав дагуух орд нь гангийн үйлдвэрлэлийн гол зах зээл болох Хятадын Синьцзян мужийн хилийн ойролцоох дэд бүтэц сайн хөгжсөн бүсэд байршилтай тул олборлолт болон тээвэрлэлтийн хямд зардлаар нийлүүлэлт хийх боломжтой. 2015 оноос 1-2 сая тонн коксжих нүүрс экспортлож, цаашдаа жилд 5-8 сая тонн хүртэл нэмэгдүүлэх боломжтой хэмээн үзсэн байна. «Celsius Coal Co.» компанийн гүйцэтгэх захирал Alexander Molyneux “Бид Монголын Овоотын ордыг эзэмшигч Монгол-Австралийн хамтарсан «Aspire Mining», Өмнөговьд үйл ажиллагаа явуулж буй «Guildford Coal» зэрэг компаниудаас илүү их хэмжээгээр коксжих нүүрсийг Хятадад экспортлох боломжтой” хэмээн 2012 оны 12 дугаар сард “Коммерсант” сонинд өгсөн ярилцлагаараа нотлов.

Оросын тэрбумтан Олег Дерипаскагийн хяналтад байдаг En+Group ОХУ-ын Бүгд найрамдах Тува Улсын уул уурхайн компани «ТГРК»-тай хамтран Тувагийн Улуг-Хемскийн нүүрсний бүсийн ордод орших коксжих нүүрсийг Кызылээс Хятадын Дундад Азийн гол бүс болсон Синьцзян руу экспортлох асуудал мөн л шийдэгдээд дуусч байна. Кызылээс холгүй орших Каа-Хемскийн ордыг оролцуулаад тэнд ойролцоогоор 20 тэрбум тонн коксжих нүүрс байршиж байгаа ажээ. Тувагаас Хятад руу нүүрс экспортлохын тулд 2007 оноос яригдсан Кызыл-Курагиногийн хооронд 411.7 км төмөр зам тавих ажил 2010 оноос эхлээд урагштай явж байгаа юм. 2014 оноос экспорт эхлэх бөгөөд 2015 он хүртэл жилд 15 сая орчим тонн, 2015 оноос цааш 15-20 сая тонн коксжих нүүрс экспортлохоор төлөвлөгдөж байгаа нь Монголын томоохон шинэ өрсөлдөгчид аль хэдийн гарч ирснийг харуулав.

2013 оны 2 дугаар сарын байдлаар Хятадад 20.9 сая тонн нүүрс экспортлож байсан Монгол Улс тэргүүн эгнээнээс “мултарч” ердөө 336 мянган тонныг нийлүүлжээ. Харин 2.58 сая тонныг экспортлосон Австрали нэгдүгээрт, удаах нь 1.21 сая тонноор Канад, гуравдугаарт ОХУ 527.3 мянга, 4 дүгээрт 408.7 мянган тонныг нийлүүлсэн АНУ орж байна. 2013 онд ОХУ-ын Өвөр Байгалийн Чита хотын цаах нь Таван толгойтой дүүцэхүйц хэмжээний нүүрсний орд шинээр илэрч, улмаар Хятад уруу өргөн царигтай төмөр зам тавьж эхэлсэн байна.

Төмөр зам геополитикийн гол суурь бүтэц байдаг учраас төмөр замын царигийн асуудал нэн чухал гэдэг нь мэдээж. Эдүгээ дэлхийн 151 оронд 1.3 сая км төмөр замын сүлжээ ашиглагдаж байгаагаас 224.7 мянган км-ээр АНУ 1 дүгээрт, 115.9 мянган км-ээр Энэтхэг 2 дугаарт, 87.1 мянган км-ээр ОХУ 3 дугаарт, 86 мянган км-ээр БНХАУ 4 дүгээрт, 46.5 мянган км-ээр (2011 он) Канад эхний тавд орж, 1810 км (2008 он) замтай Монгол Улс 75 дугаарт орж байна¹⁰. Дэлхийн төмөр замуудад хэвийн, өргөн, дунд, нарийн гэсэн дөрвөн цариг зонхилдог ажээ. Хэвийн царигтай зам дэлхийн төмөр замын 74 хувь (1435 мм-тэй 57 хувь, 1570 мм-тэй 17 хувь), өргөн 7 хувь, дунд 7 хувь, нарийн 2 хувийг эзэлж байна.

Дэлхийн ҮНБ-ийн гол хөдөлгөгч хүч болсон АНУ, ЕХ, Хятадын эдийн засаг тааламжгүй байсан 2012 онд стратегийн хөрөнгө оруулагчид тэр зүгт их хэмжээний хөрөнгө оруулах сонирхолгүй байсан нь бүрнээ зүй ёсны хэрэг бөгөөд ойлгомжтой байв. Харин чухал түүхий эд, эрчим хүчний баялаг нөөцтэй, борлуулах зах зээл нь дэргэд нь байршиж буй улс орны, өөрөөр хэлбэл төлбөрийн чадавхи бүхий Засгийн газрын бондыг худалдан авах нь хамгийн эрсдэл багатай байжээ. Бие даасан нэр хүндтэй сангууд, үндэстэн дамнасан корпорациудын зүгээс Засгийн газрын бонд, компаниудын үнэт цаас, хувьцаанаас үлэмж хэмжээгээр худалдан авч байгаа нь тэдгээр орны үндэсний баялгийн нэг хэсгийг ихээхэн хямд үнээр худалдан авч байгаагаар дэлхийн баялгийн дахин хуваарилалт явагдаж байна гэж хэлж болно. Түүгээр дамжуулан тэдгээр нь гадаад орнуудын улс төр, санхүү, эдийн засагт нөлөө үзүүлэх боломжтой болж байгаад улс орнуудын төр засгийн газрууд ихээхэн анхаарч хамгаалалтын арга хэмжээ авч байна.

Байгалийн баялаг геополитикийн хувьд хүч чадлын чухал бүрэлдэхүүн хэсэг боловч үндэсний аюулгүй байдалд аанай л эерэг, сөрөг нөлөө үзүүлсээр ирэв. Африк тив байгалийн асар их баялагтай боловч тэр нь улс орнуудынх нь хөгжилд эерэг нөлөө үзүүлэхээсээ илүүтэй баялгийн хараал болтлоо сөрөг нөлөө үзүүлж ирснийг дээр тэмдэглэсэн.

Бурханаас заяасан байгалийн асар их баялгийг байгаль орчинд ээлтэй технологиор олборлож, түүний үр шимээс ард иргэд нь тэгш хүртэж, эко орчин нь тэнцвэрээ хадгалж байх шаардлагатай. Сүүлийн 15 жилд Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтад дулдуйдсан уул уурхай эрчимтэй хөгжсөн боловч, ард иргэдэд түүний үр өгөөж өр хэлбэрээр тун чамлалттай явж ирснээр барахгүй дээрхтэй холбоотойгоор хүрээлэн буй орчны сүйрэл үргэлжилсээр байна. Үүнийг л «баялагийн хараал» хэмээн нэрлэдэг бөлгөө. Хүний гараар бүтээгдээгүй нь нэн тодорхой байгалийн баялгийг хэн нэгэн өөрийн гараар бүтээгээд хувийн өмчөө болгочихсон юм шигээр аягилах нь гэнэн мөрөөдөл билээ. Баялагийг хараал болгохгүйн тулд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг ногоон эдийн засагтай нягт уялдуулж нийт ард түмэнд тэгш хүртээх нь шударга ёсонд бүрнээ нийцнэ.

10. International Union of Railways, data 2013

“Оюу толгой”, “Таван толгой”-н гэрээний хамгийн ноцтой алдагдал нь эдгээр гэрээг байгуулахад олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлээгүйд оршино.

2002 оны 10 дугаар сард Йоханнесбургт зохиогдсон Тогтвортой хөгжлийн асуудлаарх Дэлхийн дээд уулзалтын үеэр Их Британийн Ерөнхий сайд Тони Блэйрийн санаачилгаар «Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга» (The Extractive Industries Transparency Initiative-EITI) байгууллага 2003 оны 6 дугаар сард Лондонд байгуулагдсан бөгөөд өдгөө 37 орныг эгнээндээ нэгтгэж, Монгол Улс тус санаачилгад 2006 онд нэгдэн орсон байна. Энэ байгууллагын Нарийн бичгийн даргын газар 2007 оноос Норвегийн нийслэл Осло хотноо шилжин байрлаж, тэргүүнээр нь Шведийн дипломатч Жонас Моберг ажилладаг ажээ. EITI нь олборлох салбараас төлсөн татвар, төлбөр, хураамж, тэдгээрийг хүлээн авсан орлогын ил тод байдлыг хангахад чиглэж, Засгийн газрын манлайлал, компанийн оролцоо, иргэний нийгмийн хяналт гэсэн зарчмуудын дагуу оролцогч гурван тал тэгш эрхтэйгээр хамтран ажиллах боломжийг бүрдүүлдэгт оршино. EITI таван удаа тайлан гаргахад судалгааны чанарын хувьд хөндлөнгийн үнэлгээгээр Монгол Улс 2010 онд шаардлага хангасан дэлхийн дөрөв дэх орноор хүлээн зөвшөөрөгдөж байсан ажээ.

Бурханаас заяасан байгалийн асар их баялгийг улс төрийн элдэв амлалттай холбохгүйгээр ард иргэддээ санаачлагатай хүртгэх нь аль ч УИХ, Засгийн газрын стратегийн зорилтот үндсэн ажил байх ёстой.

Эдүгээ баялгийн менежмент нэн чухал болой. Норвегийн туршлагаас тэмдэглэхэд 4.9 сая хүн амтай ЕХ-ны гишүүн бус энэ орон НҮБ-ын хөгжлийн тусламжийн хөтөлбөрүүдэд оруулдаг хандиваараа дэлхийд 10 дугаар байранд ордог, 2011 онд хөгжлийн тусламжид 5.5 тэрбум ам.доллар зарцуулжээ. Олон улсын санхүүгийн зах зээлд үнэлгээ хийдэг *Standart & Poor's* компаний итгэлцүүрээр гадаад, дотоод зээлжих зэрэглэл нь тогтмол 3А үнэлгээтэй, Засгийн газрын төсөв жил дараалан 40 тэрбум ам. долларын ашигтай гарч ирсэн байх агаад НҮБ-ын Хүний хөгжлийн индексээр дэлхийд тэргүүн байранд орж, сүүлийн жилүүдэд гадаад худалдааны ашиг 60-80 тэрбум ам. долларт хэлбэлзэж байв. Норвегийн ДНБ-ий нэг хүнд ногдох хэмжээ номинал үнэлгээгээр 2011 онд 97.2 мянган ам. доллараар Люксембургийн дараа хоёрт жагсаж, дэлхийн хамгийн өндөр хөгжил, тэгш хангалуун амьдралтай улсуудын тоонд хэдийн орсон бөгөөд уг сурвалж нь байгалийн баялагаас олж буй орлогоо хэрхэн зөв, зохистой ашиглаж байгаад оршино. Норвеги улс 1971 оноос Баренцын тэнгисээс газрын тос, хий олборлож эхэлсэн нь тус улсын эдийн засгийн гол салбар болж, улмаар тус улс газрын тос, хийн олборлолтоороо дэлхийд тэргүүлэх болов. 2011 оны байдлаар газрын тос, хий Норвегийн нийт экспортын 45 хувийг эзэлж, ДНБ-ий 20 хувь, Засгийн газрын төсвийн 28 хувийг бүрдүүлжээ.

Норвеги газрын тос, хийнээс олж буй орлогыг зохицуулж, «Засгийн

газрын тэтгэврийн сан» байгуулж, нийгмийн халамжийн зориулалтаар ашиглаж эхлэв. 2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар сангийн хуримтлал 573 тэрбум ам. долларт хүрсэн нь нэг хүнд 114 мянган ам. доллар ногдож, 2017 он гэхэд хуримтлал 900 тэрбумд хүрэх тооцоо гарчээ. Үүнээс гадна сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг олон улсын санхүүгийн зах зээл дээр байршуулснаар Европт бүртгэгдсэн нийт хувьцааны 1.25 хувь, дэлхийд арилжаалагдсан хувьцааны 1 хувийг эзэмшиж буй ажээ. Төрийн эзэмшлийн бие даасан энэхүү тэтгэврийн сан дэлхийд Арабын Нэгдсэн Эмиратын байгалийн баялгаас олсон орлогоос бүрддэг «Abu Dhabi» хөрөнгө оруулалтын агентлагийн дараа хоёрт орж байгаа юм. Норвегийн Засгийн газар байгалийн баялгаас олсон ашгаас бүрдсэн «Засгийн газрын тэтгэврийн сан»-гаар дамжуулан жил бүр ард иргэддээ тэгш хуваарилсаар ирэв. Энэ бол байгалийн баялгаа хэрхэн зөв хуваарилдгийн гайхмаар жишээ мөн. Ер нь Норвегид улсын сектор ихээхэн үр ашигтай ажилладаг, тиймээс ч хүчтэй байдаг ажгуу. Энд сайн туршлагыг авч хэрэглэх тухайд гол нь биш, харин сайн засаглал, баялгийн зөв менежмент, ил тод бодлого, үр дүнгийн тухай өгүүлж байгаа билээ.

Эрсдэлийн магадлал

Нэгд, Монгол Улсын геополитикийн харьцангуй давуу талын хүчин зүйлийн ач холбогдол аажмаар буурах хандлага ажиглагдаж болзошгүйг тэмдэглэх хэрэгтэй. Хятадад кокс нийлүүлэх шинэ тоглогчид гарч ирэв.

Хоёрт, Оюу толгойн гэрээг хоёр талын ашиг сонирхолыг тэнцүү тусгасан өөрчлөлт яаралтай оруулахгүй бол Монгол Улсад нэн ашиггүй болох нь нэгэнт тодорхой болов.

Гуравт, Дотоодын хууль, эрхзүйн орчны тогтворгүй, ойлгомжгүй байдал гадаадын хөрөнгө оруулалтыг 40 илүү хувиар буурахад хүргэсэн нь сэргээхэд зохих цаг хугацаа шаардана.

Дөрөвт, Уул уурхай, олборлолт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын салбарт ил тод байдлын санаачилга нэн сул байгаа нь авлигын эрсдэл өндөр хэвээр байгааг харуулж байна.

Тавд, Transparency International байгууллагын *Corruption Perceptions Index 2012* илтгэлд Монгол Улс авлигын индексээр 2011 онд 2.7 үнэлгээгээр 182 орноос 120 дугаарт орж байсан бол 7 үнэлгээгээр 94 дүгээр байрт орж буурсанд хоосон хөөрцөглөж, түүнийгээ огцом уналт хэмээн PR хийх шаардлага байхгүй, тийм ч гайхмаар тайвшрах үзүүлэлт биш байсан нь тодорхой болов.

Зургаад, Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллага болох ФАТФ (*Financial Action Task Force on Money Laundering-FATF*)-ийн 2013

оны 2 дугаар сарын 22-нд гаргасан *Improving Global AML (anti-money laundering)/CFT (combating the financing of terrorism) Compliance: On-going Process* тайланд Монгол Улсыг мөнгө угаах гэмт хэрэгт өндөр эрсдэлтэй (High-risk and non-cooperative jurisdictions), цагаан саарал өнгөтэй орны тоонд оруулжээ. Энэ нь авлига огцом буурсан гэх индекстэй тэс зөрж байгаа юм. Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хяналт тавиад 2 жил болж байгаа бөгөөд 49 шалгуур үзүүлэлтээс 38-д нь хангалтгүй үнэлгээ авсан ажээ. Тиймээс ойрын хугацаанд (6 дугаар сарын 15-ны дотор) холбогдох хуулиудад олон улсын байгууллагуудаас тавьдаг шаардлагуудыг тусгасан зүйл заалтуудыг тусгаж өөрчлөлт хийх шаардлага гарсан байна. Өөрөөр хэлбэл дараагийн шат болох хар саарал өнгийн жагсаалтад орвол Монголын банкуудын гадаад үйл ажиллагаа олон улсын санхүүгийн хориг арга хэмжээнд орох магадлалтай болсон юм. Монгол Улсад банк, санхүүгийн тогтолцоо хурдацтай хөгжиж, уул уурхай, байгалийн баялгийг ашиглахтай холбоотой гадаадын хөрөнгө оруулалт үлэмж нэмэгдэхийн хэрээр сүүлийн жилүүдэд зохион байгуулалтын шинжтэй, нууц далд аргаар үйлдэгддэг мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх арга, хэлбэр улам нарийсч, үндэстэн дамнасан зохион байгуулалтын шинжтэй болж байна. Монгол Улс НҮБ болон ФАТФ-ын гишүүн орны хувьд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон улсын гэрээ, конвенциор хүлээсэн үүрэг нь улам өргөн хүрээтэй болж байна. Иймд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх талаарх хяналтын тогтолцоог сайжруулах, төрийн байгууллагуудын үүргийг нарийвчлан тодорхой болгох, нэр томьёог жигдлэх, олон улсын стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр «Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль»-ийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцсэнээр 5 дугаар сарын 31-нд УИХ батлав. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг гарч болзошгүй талаар мэдээлэх үүрэгтэй байгууллагууд илт үндэслэлгүй, сэжиг бүхий их хэмжээний мөнгөн дүнтэй, улс төрийн нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийгдсэн, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх хяналт хангалтгүй улс орноор дамжуулан хийгдэж буй гүйлгээнд тусгай хяналт тавих, харилцагчийн талаарх баримт, материалыг хадгалах, сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэх, санхүүгийн мэдээллийн албанаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд тухайн дансанд хяналт тавих, гүйлгээг түр зогсоох, хөрөнгө битүүмжлэх, 20 сая төгрөгөөс дээш гүйлгээнд дээрх хяналт шалгалт хийгдэх талаарх зохицуулалтыг хуульд тусгажээ.

Долоод, Reporters Without Borders буюу «Хил хязгааргүй сэтгүүлчид» олон улсын байгууллагаас Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний 2013 оны индексийг гаргав. Энэ үзүүлэлтээр Монгол Улс 2012 оныхоос хоёр байраар ухарч 98

дугаарт жагссан байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөө жил ирэх тусам хумигдсаар байна гэсэн үг юм. 2012 онд мөн л буурч 179 орноос 100-д бичигдэж байв. Хэвлэлийн эрх чөлөөний индекс нь дэлхийн улс орнуудын эрх чөлөөний индексийг тооцоход ихээхэн нөлөө үзүүлдэг. Скандинавын улсууд болон Канад улс хэвлэлийн эрх чөлөөний индексээр тогтмол дээгүүр явдаг. Харин Хятад, Хойд Солонгос болон Ойрхи Дорнодын дотоодын үймээн самуунтай улсууд мэдээллийн эрх чөлөөг уландаа гишгэсэн хэвээр байгааг Reporters Without Borders онцолжээ. Монгол Улсын хувьд ардчилсан хэмээх тодотгол бүхий Ерөнхийлөгчтэй болоод дөрвөн жилийг өнгөрөөж, 2012 оны УИХ-ын сонгуульд АН ялж, ердийн олонх болж УИХ, Засгийн газрыг үндсэнд нь удирдаж байна. Түүнчлэн Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг Монгол Улс даргалж буй хувьд Сайд нарын ҮИИ бага хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулав. Гэвч дэлхийн улс орнуудын эрх чөлөөний индексийн үндэс болдог хэвлэлийн эрх чөлөөгөөрөө ухарсан дүн үзүүлэв.

Наймд, Хоёр хөрштэйгээ харилцах гадаад бодлогын нэгдмэл, залгамж чанар алдагдаж буйгаас таагүй нөлөө гарах магадлал байгааг үгүйсгэж үл болно.

Есд, Чингис бондын хөрөнгө оруулалтын тодорхойгүй байдал эрсдэл дагуулсан хэвээр байна. ҮАБЗ-өөс гаргасан зөвлөмжөөр бол энэ хөрөнгийг төсвийн алдагдлыг нөхөх, өр төлбөр барагдуулахад зарцуулахгүй, харин стратегийн чиглэлтэй боловсруулах үйлдвэр, аж үйлдвэрийн парк зэрэг суурь болон дэд бүтцүүдэд хөрөнгө оруулалт хийгдэнэ гэж ойлгогдож байв. 2013 оны 4 дүгээр сарын 19-нд Засгийн газрын УИХ-д танилцуулсан мэдээллээс харахад бондын хөрөнгийн 40 хувийг ноос, ноолуур, оёмол үйлдвэрлэл, хүлэмж, сүү, фермерийн аж ахуй, хот тохижилт, гудамж төсөлд зарцуулахаар төлөвлөгдсөн нь аж үйлдвэрийн парк, боловсруулах үйлдвэр, дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтад зарцуулна гэсэн анхны төлөвлөгөөтэй зөрчилдөж байна. Бонд босгоход дотооддоо ямар ч бэлтгэл байгаагүй нь томоохон эрсдэл болж байна.

Аравт, Монгол Улсын зээлийн үнэлгээ буурсан нь олон улсын хөрөнгийн бирж дээр шинээр мөнгө босгох, гадаадын хөрөнгө оруулалтад сөрөг нөлөө үзүүлнэ.

Арванэгд, Дэлхийн санхүү, эдийн засгийн таагүй байдал ойрын хугацаанд ч үргэлжилсээр байх төлөвтэй.

Арванхоёрт, Хятадын эдийн засгийн сэргэлт зохих хугацааны дараа өндөр түвшинд хүрнэ.

Арвангуравт, 2013 оны 7 дугаар сард “Bloomberg” агентлаг ард иргэд нь илүүтэйгээр бухимдан стрессдэг 74 улсын чансааг гаргав. Чансааны

эхний байруудыг таамагласан ёсоор баялаг, нийгмийн хөгжлөөрөө бусдыгаа давамгайлдаггүй, зэвсэгт мөргөлдөөн зэргээс хохирол амсаж байдаг тийм улс орнууд эзэлжээ. Түүнчлэн 100 мянган хүнд ногдох хүн амины хэргийн тоо, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, нийгмийн тэгш бус байдлын түвшин, авлигын эзлэх хэмжээ, ажилгүйдлийн түвшин, хотуудын агаарын бохирдлын хэмжээ болон дундаж наслалт зэрэг үзүүлэлтүүдийг шинжээчид шалгуур болгосон байна. Дэлхийн хамгийн өндөр “стресстэй” орноор 70.1 оноогоор Нигери улс, хоёрдугаар байрыг 70 оноотойгоор Өмнөд Африк эзлэв. Харьцангуй дундаж амьдралтай БРИКС-ийн гишүүн нь хамгийн их “стресс”-тэй бусад улсаас сондгойрч байгаа ажээ. Түүний араас Эль-Сальвадор, Монгол, Гватемал, Колумби, Пакистан, Ямайка, Македони, Боливи жагсчээ. Түүнчлэн 50-иас дээш “стресс”-ийн өндөр оноогоор Иран, Венесуэл, Босни ба Герцоговина шалгарсан бол чансааны 14 дүгээрт Энэтхэг 48,9 оноо, 15-д Египет 46,3 оноо, 17-д Бразил 45.3 оноогоор шалгарчээ. ОХУ нь 43.8 оноотойгоор жагсаалтын 25 дугаарт орж Индонези, Болгартай хаяа хатгасан аж. ОХУ-ын хувьд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ нь 15.65 мянган доллар, 100 мянган хүн тутмаасаа 10-ыг нь хөнөөчихдөг [10.2 хүн], дундаж наслалт нь 69 нас гэж шинжээчид тогтоосон байна. Ажилгүйдлийн түвшин нь ердөө 5.5 хувь байгаа нь нэн бага үзүүлэлт юм. Харин нийгмийн тэгш бус байдлын түвшнийг харуулдаг Жинийн коэффициент нь 41.7, хотуудын агаарын бохирдол нь нэг шоометрт 32,5 микрограмм ногдож байгаа ажээ. Харин стрессгүй хамгийн ая тухтай орноор шинжээчид 5.4 оноогоор Норвеги, 7.1 оноогоор Люксембург, 9.2 оноогоор Швейцари улсыг нэрлэсэн байна. Түүнчлэн 25.7 оноогоор 54 дүгээрт орсон АНУ, 24.6 оноогоор Их Британи, 22.8 оноогоор Франц, 16.6 оноогоор Герман байр эзэлсэн нь тэд тийм ч их бухимдан уцаарладаггүй ажээ. Монгол Улс дэлхийн хамгийн бухимдалтай улсын 4 дүгээрт бичигдэв. Агаарын хамгийн бохирдолтой орны 2 жагсав

Цаашлаад, ардчилалын чанарын гол хэмжүүр болсон хүний эрхийг хүндэтгэх, түүний баталгааг хангах, хууль дээдлэх, шударга ёсыг хэрэгжүүлэх, сонгуулийн ардчилсан зарчмыг тууштай баримтлах, шүүх засаглалын хараат бус байдал, засаглалын тэгш хуваарилалт ихээхэн хэврэг байна. Монгол Улс Үндсэн хуулийн ёсоор парламентын засаглалтай боловч хэрэг дээрээ Ерөнхийлөгчийн засаглалтай ч юм шиг болчихоод байгааг хууль, эрхзүйн хувьд тодотгож, тодорхой зааглах шаардлагатай. Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн гучдугаар зүйлд: «Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн» гэж заажээ.

Геополитикийн гол элемент болох хүч чадалд хамаарах зүйл бол ардчилсан ухаалаг засаглал, түүний чанар хийгээд удирдагчийн зан суртахуун, ёсзүй, зөвшилцөх чадавх бөгөөд улс орны аюулгүй байдалд шууд нөлөө үзүүлдэг. Энэ бол Монгол Улсад хамаарах магадгүй хамгийн гол хүчин зүйл мөн болой. Цөөнхийг хүндэтгэх нь олонхийг бүрдүүлж буй улс төрийн намын

том соёл, ардчилсан төрийн чухал шинж болой.

УИХ-ын сонгуульд намын жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ зөвхөн хоёр удаа л бичүүлэх хууль, эрхзүйн орчинг бүрдүүлэхгүй бол өөрсдийгөө мөнхөд сонгуулах сонирхолтой улс төрчид байгаа нь тодорхой байна. Түүнчлэн улс төрийн болон тодорхой албан тушаалын томилгоонд мэргэжлийн чиглэлийг баримталж байх эрхүйн орчинг ч бүрдүүлж, төрийн мэргэшсэн байх шинж чанарыг тууштай хангах ёстой. Мөн нэр дэвшигчийг шүүхийн шийдвэрээр УИХ-д сонгодог, нэгэнт тангараг өргөсөн гишүүнтэй сонгуулийн маргаан үүсгэх зэрэг үзэгдэл хэвшил болж мэдэхээр байна.

Монгол Улс сүүлийн 20 гаруй жилд ардчилалын замд томоохон амжилт олсон ч, үүндээ эрэмшсэн улс төрчид ардчилалыг өмчилж, улмаар түүний нэрээр халхавч хийж, Монгол шиг бүрэн ардчилагдчихсан, энэ чиглэлд үлэмж үсрэнгүй амжилт олчихсон, гайхмаар орон байхгүй юм шигээр авирлаж буй нь «коммунизм дахь “зүүний” нялхсын өвчин»-г эрхгүй санагдуулдаг. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга А.Амар 1934 онд хуралдсан Улсын IX хурал дээр хэлэхдээ: «Бидний өчүүхэн бага монголчууд дэлхий дахины төлөөнөө санаа зовохоос урьд Монголын төлөө санаа зовбоос зохистой бөгөөд дэлхий дахины хэмээн өгүүлэхээс урьд Монгол хэмээн өгүүлвээс зохистой байх агсан амой» хэмээн дэлхийн хувьсгалын тухай лозунгонож байсан “зүүнтэн”-ий адал балмад үйл ажиллагааг илчлэн шүүмжилж байсныг сануулахад илүүдэх юун. Татах хүчийг үл хэрэгсэн өөрийн хөрснөөс жингүйдэн дэлхий дахинд ардчилалыг түгээх талаар хошууран ярих болсон нь ардчилал нь зарим талаар зар сурталчилгаа, шоуны шинжтэй болж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Энэ нь яваандаа ардчилалыг хууль бус бусармаг үйлдлийг халхавчлах хэрэгсэл болгож болзошгүйг анхаарах шаардлагатай. Монгол Улс «Ардчилалын төлөөх Азийн түншлэл» гэсэн санаачилга дэвшүүлж, бүс нутгийн зөвлөлдөх механизм бий болгох талаар хүч чармайлт гаргахаар ажиллаж буй нь бүс нутгийн орнуудыг зарим талаар ялгаварлах шинжтэй байгааг болон үүнд хоёр хөрш анхаарлаа хандуулж буйг анхаарах хэрэгтэй болов уу.

Монгол Улс АОХН-ийг даргалж буй орны хувьд Сайд нарын ҮИИ чуулга уулзалтыг 2013 оны 4 дүгээр сарын 27-29-нд Улаанбаатар хотноо «баяр ёслолын байдалтай»-гаар зохион байгуулав. Уригдан оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүн, зэрэг зиндаа төлөвлөгдөж байснаас бага зэрэг өөрчлөгдсөн ч тус улсын олон улсын нэр хүндийг зохих хэмжээнд харуулснаас гадна хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүдийн хувьд харьцангуй хаалттай, Монголын ардчилалд тулгарч буй асуудал, сорилтын талаар ул суурьтай хэлэлцэж чадаагүй тухайд судлаачид, улс төрчид, дотоод, гадаадын хэвлэлүүд шүүмжлэлтэй хандаж байсан нь үнэн юм. Гадныхан Монголын ардчилалаас суралцахаар ирэх болов гэж сурталдах нь гадаад орнуудыг басамжилсан хэрэг байв.

2012-13 оны гол онцлог нь Монгол Улсад болон түүний геополитикийн

орчинд хөрш гүрнүүд болон «гуравдагч хөрш»-үүдэд парламентын болон ерөнхийлөгчийн сонгууль явагдаж, төр засгийн удирдлага солигдож, мөн улиран сонгогдов.

Өөр нэг илэрхий бодит байдал нь дэлхийн соёл иргэншил, улс үндэсний хувь заяанд нөлөөлж болохуйц уламжлалт бус аюул буй болж заналхийлэх болсон явдал мөн. Монгол Улсын зэвсэгт хүчин Энхийг сахиулах болон олон улсын цэргийн ажиллагааны хүрээнд Ирак, Афганистан, Сьерра Леон, Чад, Судан улсад үүрэг гүйцэтгэж байгаа нөхцөлд олон улсын чанартай уламжлалт бус аюулаас урьдчилан сэргийлэх, юуны өмнө олон улсын терроризм, салан тусгаарлах үйл ажиллагаа, шашны харгис урсгалуудын нөлөө нэвтрэх магадлал өндөр байгааг огт үгүйсгэж болохгүй. Хоёр их гүрний дунд оршиж буй Монгол Улсад хууль бусаар мансууруулах бодис, хар тамхи тээвэрлэх, дамжин өнгөрүүлэх, тараах, хэрэглэх, хүн худалдаалах, мөнгө угаах, галт зэвсгийн хууль бус наймаа зэрэг олон улсын чанартай үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг гарах боломж, нөхцөл нэгэнт бүрдсэн бөгөөд гарч эхэлж байна. Төв Азийн бүс нутагт террорист байгууллагад бүртгэгдсэн бүлэглэлүүдийн үйл ажиллагаа идэвхжиж, элдэв халдлага, дайралтууд өргөжин, үйл ажиллагаагаа тэлэх хандлагатай байгаа нь Монгол Улсын өргөн уудам газар нутаг, хөгжлийн одоогийн нөхцөл байдлыг ашиглан нэвтрэн суурьших магадлал ч байгаа юм. Хилийн худалдаа өргөжиж байгаатай холбоотойгоор хилийн боомтууд шинээр нээгдэж, энэ нь хууль бусаар түүх-дурсгал, палеонтологийн эд зүйлс, мансууруулах бодис, хар тамхи, галт зэвсэг, хүн худалдаалах, ангийн үс, ховор ан амьтан, эмийн ургамал, татвараас займчуулсан их хэмжээний алт зэргийг хууль бусаар гадаадад гаргах боломжийг өргөжүүлж байгаа юм. Энэ нь албан тушаалтан авилгад автах боломж нөхцлийг бүрдүүлж байгааг үгүйсгэж үл болно.

Хөгжиж буй орнууд олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламж, заавар зөвлөмж, их гүрнүүдийн нөлөө ивээл, үндэстэн дамнасан бизнес бүлэглэлүүдийн томоохон хөрөнгө оруулалтад улам бүр зулгуйдан дулдуйдах болсон нь эдгээр орнуудын хөгжлийн асуудал, үндэсний аюулгүй байдлын тодорхой хэсэг тэдгээрээс олон талаар шууд хамаарах болов. Нөгөө талд дэлхийн эдийн засаг даяаршиж, бие биенээсээ улам бүр харилцан хамааралтай болж, ямар ч хүчирхэг эдийн засагтай улс гүрэн ч өөрийнхөө хөгжил дэвшил, үндэсний аюулгүй байдлаа дангаараа хангаж, хөтлөн авч явах бололцоогүй болж байна. Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт улам бүр хөнгөвчлөгдөж, ДХБ-аар зохицуулагдах болсон ч чөлөөт худалдаа нь жижиг бага улс орнуудын эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж, хамгийн сонгодог гэгдэх ЕХ-ны интеграци, нэгдсэн валютын бодлого томоохон сорилттой тулгарч эхлэв. Үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй болов.

Бүс нутгийн интеграциуд өөр хоорондоо хамтын ажиллагаагаар холбогдож транс-континенталь шинж чанартай болж байгаа бөгөөд үүний тодорхой илрэл нь Монгол Улс бүрэн эрхт гишүүнээр нь элссэн АСЕМ (Asia-Europe Meeting), ФЕАЛАК (Forum for East Asia-Latin America Cooperation-FEALAC) зэрэг байгууллагын үйл ажиллагаа болно. Тиймээс цаашид Монгол Улс энэ чиглэлд хамтран ажиллах бодлогоо боловсруулж гаргах шаардлагатай.

Хоёр их гүрний асар том зах зээлийн эрэлт, хэрэгцээ, гадаадынхны сонирхлыг татаж буй уул уурхай, эрчим хүч, эрдэс баялгийн үлэмж нөөц зэргээс гадна Монгол Улс геополитикийн онцлог байршилдаа зохицон Ази-Европ тивийн хооронд иж бүрэн ложистик хангагдсан «газрын гүүр» болж, үүнийг аялал жуулчлалтай хослуулсан идэвхтэй транзит орон болох ёстой.

“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д зааснаар мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд тулгуурлахын ач холбогдол хэлбэрэлтгүй өсөн нэмэгдэж байна. Даяаршлын үйл явцад улс орны бүх салбар, хувь хүн хамрагдаж, харилцан хамаарал үндэсний аюулгүй байдлыг тодорхойлогч нэг томоохон хүчин зүйл болов. Даяаршлын боломж бол хамтран ажиллаж, хамтаар хожих явдал мөн.

Харилцан хамааралтай болсон даяаршлын эдүгээ үед дэлхийн болон дотоодын худалдаа-эдийн засаг, валют-санхүүгийн тогтвортой байдал Монгол Улсын хөгжил дэвшил, үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлж байна. Ойрх үеийн томоохон сорилт нь дэлхийн түүхий эдийн зах зээл дээрх Монгол Улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн зэс, алт, нүүрс, импортын шатахууны үнийн өөрчлөлт, валютын ханшны хэлбэлзэл, цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшиг, уламжлалт бус шинэ өвчний цар тахал, эдийн засгийн ухаалаг зөв бодлого, ардчилал, сонгуулын тогтолцоо, засаглалын хямрал зэрэг болно. Тиймээс «гуравдагч хөрш»-ийн бодлогын хүрээнд урьдчилан сэргийлэх дипломат ажиллагаа (*preventive diplomacy*), хямралын менежмент (*crisis management*) нэн чухал. Эдийн засгийн мэргэн бодлого, ардчилалын чанарын хэмжүүр болсон хүний эрхийн баталгаажилт, хууль дээдлэх, шударга ёсыг хэрэгжүүлэх, олонх нь цөөнхөө хүндэтгэх, ухаалаг засаглалыг цогцлоох нь амин чухал гэдэг нь ч тодорхой.

Даяаршлын үйл явцад улс орны бүх салбар хамрагдаж, харилцан хамаарал үндэсний аюулгүй байдлыг тодорхойлогч нэг томоохон хүчин зүйл болов. Ийм түүхэн үед улс хоорондын харилцаанд эрх тэгш байх, шударга байх, олон хэлбэртэй байх, хамтын хариуцлага хүлээх зэрэг үндсэн зарчмын ач холбогдол өсч байна. Даяаршлын боломж бол хамтран ажиллаж, хамтаар хожих явдал мөн.